

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭ**

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Тайлан	Хугацаа	
1	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн нэгдсэн системээр бүртгэн шилжүүлсэн нийт өргөдөл, гомдол – 1417	2025.01.02 2025.12.22	
	Шийдвэрлэх шатандаа байгаа - 36		
	Хугацаандаа шийдвэрлэсэн - 1381		
	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн - -		
	Иргэний талд шийдвэрлэсэн - 953		
	Боломжгүй тухай хариу өгсөн – 427		
	Бусад – 1		
Шийдвэрлэлт - 97.0%			
2	Хэлтэс, нэгжид хувиарлагдсан өргөдөл, гомдлын тоо:	2025.01.02 2025.12.22	
	Захиргаа, удирдлагын хэлтэс – 311		
	Тээврийн бодлого, судалгааны хэлтэс– 457		
	Санхүү, аж ахуйн хэлтэс – 36		
	Зорчигч, тээврийн хэлтэс – 137		
	Хяналт шалгалтын хэлтэс – 395		
	Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс – 29		
	Бүртгэл, техник, технологийн хэлтэс – 8		
Хуулийн хэлтэс- 44			
3	Гомдол – 643	2025.01.02 2025.12.22	
	Хүсэлт – 657		
	Санал – 108		
	Талархал – 9		
	Зөрчил- 0		
Мэдэгдэл- 0			
<b>Зөрчлийн тоон үзүүлэлт</b>			
4	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	2	2025.01.02 2025.12.22
5	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	3	
6	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	5	
7	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	-	
8	Дундаж хоног	7 хоног 21 цаг 9 минут	
9	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-	

• Тус газрын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн UB ERP нэгдсэн системд 2025 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар нийт **1417** өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 1381, шийдвэрлэх шатандаа байгаа 36 өргөдөл, гомдол байна.

## **Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу зохион байгуулан хэрэгжүүлсэн ажлын талаар:**

Нийт ирсэн өргөдөл, гомдлын 643 буюу 43.7 хувь “Гомдол” байгаагаас Хяналт шалгалтын хэлтэст-299, Тээврийн бодлого, судалгааны хэлтэст-187, Зорчигч, тээврийн хэлтэст-81, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэст-15, Захиргаа, удирдлагын хэлтэст-7, Бүртгэл, техник, технологийн хэлтэст-4, Санхүү, аж ахуйн хэлтэст-18, Хуулийн хэлтэст-32 гомдол ирсэн байна.

Шийдвэрлэсэн байдал: Гомдлын дагуу боломжгүй тухай хариу өгсөн 190, бусад-1, гомдол гаргагчид мэдээлэл өгч иргэний талд шийдвэрлэсэн 441, шийдвэрлэх шатандаа байгаа 16 гомдол байна.

Дээрх ирсэн гомдлуудыг агууллагаар нь харуулбал: Нийтийн тээврийн салбарын үйл ажиллагааны тухай-143, Автобусны жолоочийн үйлчилгээний соёлын тухай-77, Автобусны тоо, чиглэл нэмэх, өөрчлөх-50, Автобусны чиглэл, маршрутын тухай-49, Буудал дээрх автобусны зогсолтын тухай-46, Автобусны буудал, зогсоол шинээр нээх, цэгцлэх тухай-36, Автобусны цагийн хуваарийн тухай-35, Автобусны жолооч, кондукторын үйлчилгээний соёлын тухай-28, Нийтийн тээврийн үйлчилгээний аюулгүй байдал, стандартын тухай-22, Автобусны буудал нэмэх, буудлын тохижилтын тухай-22, Автобусны карт цэнэглэлтийн тухай-16, Автобусны карт уншигч төхөөрөмжийн тухай-16, Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай-9, Автобусны жолооч, кондукторын үйлчилгээний соёлын тухай-7, Нийтийн тээврийн хэрэгслийн үнэ тариф, хөнгөлөлтийн тухай-7, Замын хөдөлгөөний ачаалал, түгжрэл, зохицуулалтын тухай-6, Замын хөдөлгөөний аюулгүй байдал зөрчсөн тухай-6, Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагуудын үйл ажиллагааны тухай-6, Автобусны цэвэрлэгээ, үйлчилгээний тухай-5, Тов оврын тээврийн хэрэгслийн зөрчлийн тухай-4, Цалин, хөлсний тухай-3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай-3, Нийгмийн халамжийн үйлчилгээний тухай-3, Автобусны шалгагчийн үйлчилгээний соёлын тухай-3, Автобусны жолооч бэлэн мөнгө авсан тухай-3, Орон сууцны 1-р давхарт байрлах үйлчилгээний газруудын тухай-3, Буудал зарлагч төхөөрөмжийн ажиллагааны тухай-3, Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны тухай-2, Нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай-2, Зар сурталчилгаа, мэдээллийн самбарын тухай-2, Зам, тээврийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай-2, Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай-2, Авто зогсоол, төлбөртэй зогсоолын тухай-2, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-1, Ажлын сахилга, хариуцлагын тухай-1, Такси үйлчилгээний тухай-1, Ажилгүйдлийн даатгалын тухай-1, Хувийн аж ахуй, фермерийн үйл ажиллагааны тухай-1, Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой зөрчил-1, Авто тээврийн хяналтын тухай-1, Жижиг дунд үйлдвэрийн тухай-1, Хөдөлмөр эрхлэлтийн тухай-1, Жолооны үнэмлэх хэвлэлтийн тухай-1, Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай-1, Хөдөлмөрийн харилцаа, маргааны талаар зөвлөмж авах тухай-1, Нийтийн бие засах газрын тухай-1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай-1, Хот тохижилтын тухай-1, Зах болон худалдааны төв, дэлгүүрийн худалдаа, үйлчилгээний тухай-1, Замын тэмдэг, тэмдэглэгээний тухай-1, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон ил задгай худалдаа, үйлчилгээний тухай-1, Хороодын үйл ажиллагааны тухай-1 тус тус гомдлууд ирсэн байна.

Гомдол мэдээллийн дагуу Сар шинийн баяр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Мартын-8”, Бурхан багшийн Их дүйчин өдөр, “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, “Хүүхдийн баяр” зэрэг бүх нийтийн баярын өдрүүдээр нийтийн тээврийн хэрэгслийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан, мөн нийслэл хотод зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээ “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, “Мазаалай” арга хэмжээтэй холбоотой 2 чиглэлд 6

тээврийн хэрэгсэлд өөрчлөлт оруулсан, Сар шинийн баярыг угтаж 2025 оны 03 дугаар сарын 01-05-ны өдрийг бүх нийтийн амралтын өдөр болгосонтой холбоотойгоор амралтын өдрөөр ажиллахаар нэгдсэн даалгаварт өөрчлөлт оруулсан, “Дугуйтай Улаанбаатар марафон 2025” арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсантай холбоотойгоор нийтийн тээврийн 42 чиглэл, 13 дахь жилдээ зохион байгуулагдаж буй "POWER Expo & Festival 2025" арга хэмжээтэй холбоотой 1 чиглэл, “Улаанбаатар Марафон 2025” гүйлтийн арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсантай холбоотойгоор нийтийн тээврийн 50 чиглэлд, Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан “Нисэх хүчин-100 жил” эйр шоу арга хэмжээ зохион байгуулагдсантай холбоотойгоор 3 чиглэлд, Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ой, Монгол Улсад хүүхдийн төлөө байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Монгол хүү 2025” хүүхдийн баярын арга хэмжээ Хүй долоон худагт 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан. Уг арга хэмжээний хүрээнд Хүй7:2 “МУБИС – Хүй 7 худаг” чиглэлд иргэдэд 4 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан энэ оны 06 дугаар сарын 01-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсантай холбоотой 5 чиглэлийн өөрчлөлтүүдийг боловсруулж нэгдсэн даалгаварт тусгаж ажилласан.

Гомдол мэдээллийн дагуу шинээр нээж, өөрчлөлт оруулсан чиглэлүүд:

1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс:

- ✓ М:1А “5 шар- Мөнгөн Завьяа”,
- ✓ М:1Б “Сүхбаатарын талбай- Офицеруудын ордон” чиглэлийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/26 дугаар тушаалаар,
- ✓ 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар АТ:4 “Нисэх-5 шар – Гандан- Халдварт өвчин судлалын үндэсний төв”,
- ✓ АТ:5 “Улиастайн шинэ эцэс- Улаанхуаран- Халдварт өвчин судлалын үндэсний төв”,
- ✓ 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/41 тоот тушаалаар М:3а “Архивын ерөнхий газар – Таван богд компани”,
- ✓ Ч:7а “Нисэх - Таван богд компани” чиглэлүүдийг шинээр нээж,
- ✓ Х:19 “Чингис хаан ОУНБ-Сүхбаатарын талбай”,
- ✓ Х:20 “Чингис хаан ОУНБ-Буянт-Ухаа спорт цогцолбор” чиглэлийг сэргээж,

**ЧИГЛЭЛ: Х:20**  
**ЧИНГИС ХААН ОУНБ-ТАВАН ШАР**

Таван шар - Чингис Хаан ОУНБ руу		Чингис Хаан ОУНБ - Таван шар	
Хөдөөх	Ирэх	Хөдөөх	Ирэх
06:15	07:05	07:15	08:05
06:35	07:45	07:35	08:45
07:55	08:25	08:55	09:25
08:15	09:05	09:15	10:05
09:55	10:45	10:05	10:55
09:35	10:25	10:45	11:35
10:15	11:05	11:25	12:15
11:05	11:55	12:05	12:55
11:45	12:35	12:45	13:35
12:25	13:15	13:25	14:15
13:05	13:55	14:05	14:55
13:45	14:35	14:45	15:35
14:25	15:15	15:35	16:25
15:05	15:55	16:15	17:05
15:45	16:35	16:55	17:45
16:35	17:25	17:35	18:25
17:15	18:05	18:15	19:05
17:55	18:45	18:55	19:45
18:35	19:25	19:35	20:25
19:15	20:05	20:15	21:05
19:55	20:45	20:55	21:45
20:35	21:25	21:35	22:25
21:15	22:05	22:15	23:05

**ЧИГЛЭЛ: Х:19**  
**ЧИНГИС ХААН ОУНБ-СҮХБААТАРЫН ТАЛБАЙ**

Сүхбаатарын талбай - Чингис Хаан ОУНБ		Чингис Хаан ОУНБ - Сүхбаатарын талбай	
Хөдөөх	Ирэх	Хөдөөх	Ирэх
06:15	07:25	07:35	08:45
06:55	08:05	08:15	09:25
07:35	08:45	08:55	10:05
08:15	09:25	09:35	10:45
08:55	10:05	10:15	11:25
09:35	10:45	10:45	12:15
10:15	11:25	11:25	12:35
10:55	12:05	11:45	12:55
11:35	12:45	12:15	13:25
12:15	13:05	13:15	14:25
12:55	13:55	14:05	14:55
13:35	14:45	14:25	15:35
14:15	15:35	15:05	16:15
14:55	16:25	15:45	17:15
15:35	17:05	16:25	17:45
16:15	17:45	17:05	18:25
16:55	18:25	17:45	19:05
17:35	19:05	18:25	19:45
18:15	19:45	19:05	20:25
18:55	20:25	19:45	21:05
19:35	21:05	20:35	21:45
20:15	21:45	21:15	22:25
20:35	21:55	21:55	23:05

Зураг 01. Чингис хаан нисэх буудал рүү хүргэж буй үйлчилгээний цагийн хуваарь



- ✓ 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/74 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар Д:1 "Шархад - Хангамж - Ботаник" чиглэлийн замналд өөрчлөлт оруулж
- ✓ хоёрдугаар хавсралтаар Д:10 "Офицеруудын ордон - Баганат өргөө хороолол - Шархад - 158-р сургууль" чиглэлийн замналд дундын зогсоол нэмсэн.
- ✓ 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/75 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Ч:7 "Нисэх - МУБИС - Ард кино театр", хоёрдугаар хавсралтаар
- ✓ Ч:9 "Нисэх - Нарны гүүр - Тэнгис кино театр - Хүнсний 4-р дэлгүүр" гуравдугаар хавсралтаар



Зураг 04. Ч:7, Ч:9 чиглэлийн зураглал

- ✓ Ч:22 "Шадивлан эцэс - Бөмбөгөр - Чингис соосэ ДС - Далангийн зам" чиглэлүүдийн замналд өөрчлөлт оруулж,
- ✓ дөрөвдүгээр хавсралтаар Ч:82 "Далангийн зам - Чингис Соосэ ДС - 10 дугаар хороолол" чиглэлийн нээсэн.
- ✓ 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/88 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн 8, 11, 12 дугаар хорооны иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор М:1Б "Сүхбаатарын талбайн төв зогсоол - Офицеруудын ордон" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.
- ✓ 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Ч:71 "120 мянгат - Хүннү 2222 - Баянмонгол хороолол - Сүхбаатарын талбай" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.
- ✓ 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/92 дугаар тушаалаар Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор Х:19 "Чингис хаан олон улсын нисэх буудал - Сүхбаатарын талбай" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.
- ✓ 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/97 дугаар тушаалаар Багануур дүүргийн иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах зорилгоор "Х:17 Багануур - Тэнгэр плаза" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.
- ✓ 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/98 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах зорилгоор "Ч:84 "Бага тэнгэр сити - Хан хиллс хотхон - 120 мянгат" чиглэлийг шинээр нээсэн.

- ✓ 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хорооны иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ хүргэх зорилгоор ЗҮ:4 "Гүнт - Жигжид - Шадивлан - 7 буудал" чиглэлийг шинээр нээсэн.
- ✓ 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/105 дугаар тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээний Х:8 "Найрамдал - 5 шар" чиглэлийн зогсоолын нэршлийг сольж, дундын зогсоол нэмсэн.
- ✓ 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Д:1 "Шар хад - Улиастайн хуучин эцэс - Хангамж" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан, Баянзүрх дүүргийн 24 дүгээр хорооны иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор Д:11 "Офицеруудын ордон - Цахлай - Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо" чиглэлийн замналыг хоёрдугаар хавсралтаар,
- ✓ Баянзүрх дүүргийн 35 дугаар хорооны иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо - Улиастайн шинэ эцэс" чиглэлийн замналыг гуравдугаар хавсралтаар,
- ✓ Д:13 "Улиастайн шинэ эцэс - Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо" чиглэлийн замналыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус нээсэн.
- ✓ 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/115 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах зорилгоор Ү:24 "Ургах наран хороолол - Офицеруудын ордон" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.
- ✓ Багахангай дүүргийн 1, 2 дугаар хорооны иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/117 дугаар тушаалаар Х:18 "Улаанбаатар (Тэнгэр плаза) - Багахангай эцсийн зогсоол" чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан.
- ✓ Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/118 дугаар тушаалаар М:1А "5 шар - Мөнгөн завъяа" чиглэлийн замналд тус тус өөрчлөлт оруулсан.

Тайлант хугацаанд нийт 14 чиглэлийг шинээр нээж 16 чиглэлд өөрчлөлт оруулснаас 14 чиглэл нь богино эргэлтийн, 8 чиглэл нь гэр хорооллын үйлчилгээ хүрээгүй цэгт шинээр үйлчилгээ хүргэсэн байна.

2.Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын сарын 10-14-ний өдрүүдэд тус газрын нийт жолооч нартай биечлэн уулзаж, ажлын явцад үүсч буй бэрхшээл, сайжруулах боломжийн талаар санал солилцсон. Уг үйл ажиллагаанд Нийтийн тээврийн бодлогын газрын Сургалт хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч. Бадамханд, Авто тээврийн хяналтын Улсын байцаагч Б. Мягмардорж нар оролцож хамтран ажилласан. Мөн тус газраас хэрэгжүүлж буй ажлууд болон MNS:5012:2021 стандартын хэрэгжилтийг танилцуулж, жолооч нартай холбоотой иргэдээс ирүүлсэн санал гомдлыг танилцуулав. Түүнчлэн зорчигч төвтэй үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд юуг анхаарах талаар зөвлөлдөв.



Зураг 05. Сургалтын үйл явцаас

3. НИТХ-ын ээлжит II хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, Багануур, Багахангай чиглэлээс бусад бүх чиглэлд 2025 оны II сарын 01-ний өдрөөс эхлэн нийтийн тээврийн үйлчилгээний зориулалтын картаар 1000 төгрөгөөр өдөрт 4 удаа чиглэл харгалзахгүй зорчих боломж бүрдсэн.

### ЗОРЧИГЧДЫН ТӨЛБӨР ТӨЛӨХ БОЛОМЖ

Нийтийн тээврийн үйлчилгээнд одоо ашиглагдаж байгаа төлбөрийн систем нь хэвээр ажиллах бөгөөд U-money картаар төлбөрөө үргэлжлүүлэн төлөх боломжтой. Мөн ХАС, ХААН, ГОЛОМТ, Худалдаа хөгжлийн банкны U-Money хамтарсан картаар төлбөр төлөх боломжтой

2025 оны 2 дугаар сарын 1-нээс төлбөрийн шинэ боломжууд нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь UBCard гар утасны аппликэйшн, UBCard шинэ төлбөрийн карт юм. Гар утасны UBCard аппликэйшн ашиглан QR кодыг уншуулж төлбөр төлөх боломжтой. Цаашид Улаанбаатар хотын хүн амын нягтаршил ихтэй 100 цэгт Киоск байршуулах бөгөөд уг төхөөрөмжөөс шинээр хэрэглээнд нэвтэрч буй шинэ төлбөрийн картыг худалдан авах, цэнэглэх боломжтой юм. Түүнчлэн бэлэн мөнгө болон бүх банкны NFC дэмждэг картаар үйлчлүүлэх боломж хэвээр бөгөөд та энэ боломжоо ашигласан тохиолдолд зорчих бүрд 1000 төгрөг төлнө.

#### КИОСК ТӨХӨӨРӨМЖ

Киоск төхөөрөмжөөс дараах үйлчилгээг авах боломжтой.

1. UBCard картыг 3600 төгрөгөөр худалдан авах, картаа цэнэглэхдээ Qpay, Social pay, банкны пос машиныг ашиглах боломжтой.
2. UBCard карт авахгүйгээр нэг удаагийн QR-кодтой тасалбар худалдан авч, төлбөрийг Qpay, Social pay, банкны пос машинаар төлөх боломжтой

#### ЛЕД САМБАР


Одоогийн байдлаар 100 автобусны зогсоолд нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийн Led самбарыг байршуулсан. Энэ самбараас иргэд, зорчигчид тухайн зогсоолоор дайран өнгөрдөг чиглэлүүдийг харахаас гадна хэдэн буудлын дараа ямар автобус ирж байгааг харах боломжтой.

#### АППЛИКЕЙШН

UBCard аппликэйшний даваа тал, боломжуудийг олгоно:

1. QR кодоор төлбөр төлөх;
2. Зорчилт, цэнэглэлтийн түүхээ харах;
3. Ашиглаагүй үлдэгдлээ шилжүүлэх;
4. UBCard картаа заавал үйлчилгээний цэгт очилгүйгээр дурын газраас өөрөө цэнэглэх;

5. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, зогсоол, цагийн хуваарийн талаар мэдээлэл авах;
6. Тухайн автобусны зорчигчийн дүүргэлтийг харах;
7. Замчлуулах;
8. Нийтийн тээвэртэй холбоотой санал, хүсэлт, гомдол илгээх
9. Нийтийн тээврийн талаар шинэ мэдээлэл хүлээн авах



Зураг 06. UBCard аппликейшн

4.Зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, сургуулийн бүсэд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлж, сурагч гэр сургуулийн хооронд үнэ төлбөргүй зорчих "Сургуулийн автобус" төслийг тав дахь хичээлийн жилдээ хэрэгжүүлж байна. Сурагчдын амралт дуусч шинэ улирлын хичээл эхлэж байгаатай холбоотой аюулгүй үйлчилгээг хүргэх зорилгоор сургуулийн автобусны жолооч, хүүхэд зохицуулагч нарт “Хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгааллын мэдлэгийг нэмэгдүүлэх нь” сургалтыг өнөөдөр Нийслэлийн Боловсролын газар, Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-уудтай хамтран зохион байгуулав. Сургалтад сургуулийн автобусны жолооч, хүүхэд зохицуулагч нийт 117 хүн хамрагдлаа.

5. Нийтийн тээврийн салбарт ажиллагсдад 2025 оны 06 дугаар сарын байдлаар 4 чиглэлээр 29 удаагийн сургалтаар нийт 2330 инженер, техникийн ажилтан, жолооч, захиргааны ажилчдыг сургалтад хамруулсан байна. Үүнд:

1. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч нарт 16 сургалтаар 1174 жолооч;

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр 2 сургалтаар 118 инженер, техникийн ажилтан;

3. Салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн чиглэлээр 5 сургалтаар 98 инженер, техникийн ажилтан;


4. Нийтийн тээврийн салбарын бусад чиглэлээр 1 сургалтаар 40 инженер, техникийн ажилтан, ерөнхий боловсролын 900 сурагч.

Сургалтыг Нийслэлийн Боловсролын газар, Тээврийн цагдаагийн газар, Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Нийслэлийн Онцгой байдлын газар, Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбоо, ICT групп ХК, Грийн энерги моторс ХХК, Ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн ерөнхий газар, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.



Зураг 06. Сургалтын үйл явцаас

6.Нийтийн тээврийн бодлогын газар болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, жолоочийн талаарх санал хүсэлт, гомдол, талархал мэдээллээг <https://ptd.ub.gov.mn/> хаягаар хүлээн авдаг болсон.



Зураг 06. Иргэдээс санал хүсэлт, гомдол, талархал хүлээн авах

7.Скайвелл маркийн цахилгаан автобусны ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой танхимын болон практик сургалтыг Грийн Энержи Моторс компанитай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 21- нээс 23-ны өдрүүдэд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-т зохион байгуулж байна. Сургалтыг “Грийн Энержи Моторс” ХХК-ийн төлөөллүүд болон “Нанжин Голден Драгон Бус” ХХК-ийн мэргэжилтэн инженер Жао Жихун нар удирдан явуулж байна. Дээрх автобусыг ашиглагч Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын инженер засварчдаас гадна бусад ОНӨААТҮГ-ын инженер, техникийн ажилчид сургалтад хамрагдсан.



Зураг 07. Сургалтын үйл явц

8.Нийтийн тээврийн бодлогын газрын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А29 дүгээр тушаалийн дагуу М:5, Ү:30 чиглэлийн замналд Эрдэнэдрийлинг зогсоол шинээр нэмэгдлээ. 2025 оны 03 дугаар сарын 18-наас системд орж тухайн зогсож эхэлнэ.



Зураг 08. Шинээр нэмэгдсэн чиглэл

9. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/72 дугаар тушаалаар “Дүнжингарав худалдааны төв-Баянмонгол хороолол-Сүхбаатарын талбай” гэсэн шинэ чиглэл нээсэн.



Зураг 09. Шинээр нэмэгдсэн чиглэл

Оны эхнээс 9008 чиглэлд үйлчилгээнд ажиллаж байгаа их болон дунд багтаамжийн 1186 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж. Давхардсан тоогоор 51431 тээврийн хэрэгсэлд 65314 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 98885 зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, 40384 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, 67959 зорчигчийн картанд Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 3.120.971.500 мянган төгрөгийн цэнэглэлт хийж ажилласан.

Оны эхнээс Энхтайвны өргөн чөлөөнд ажиллахдаа автобусны буудлын “Зогсоолын талбай”-д хориглосон цагаар зогссон 20998 автомашины зөрчлийг фото

зургаар баримтжуулан “E-Police application”-ээр Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү шилжүүлснээс 13369 зөрчил баталгаажиг гэрийн хаягаар илгээн, нийт 267.380.000 төгрөгийн торгууль оногдуулсан. 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс 102-Police application –аар солигдож Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү 3658 автомашины зөрчлийг фото зургаар баримтжуулан ажиллаа. Мөн Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 54 зорчигчийн зөрчлийг илрүүлж, 1.250.000 төгрөгийн шийтгэл ногдуулж ажиллалаа.

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарь мөрдөлт, баримт бичгийн бүрдэл, гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад хяналт тавин ажиллаа. Зөрчлийг арилгуулах зорилгоор давхардсан тоогоор улсын байцаагчийн 104 заалт бүхий 54 албан шаардлага, 313 тээврийн хэрэгсэлд 2709 заалт бүхий 150 техникийн дүгнэлт гаргасан.

Автотээврийн хяналтын 10 улсын байцаагч 18 аж ахуйн нэгжийн өглөөний эх авалтаар 1134 тээврийн хэрэгсэл “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба түүнд тавигдах шаардлага” MNS 5012:2021, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, улсын стандартын нөхцөл шаардлага хангасан эсэхийг шалгаж, 54 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа.

Иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч нар ажиллаж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллага, 813 иргэн, автобусны жолооч нарын гаргасан 981 зөрчилд 98,670,000 сая төгрөгийн торгууль шийтгэврийн хуудсаар тавьж ажиллалаа.

### **Иргэдээс ирүүлсэн саналын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:**

Нийт ирсэн өргөдөл, гомдлоос 108 буюу 7,6 хувь “Санал” байгаа нь Тээврийн бодлого, судалгааны хэлтэст-68, Зорчигч, тээврийн хэлтэст-14, Хяналт шалгалтын хэлтэст-16, Хуулийн хэлтэст-3, Санхүү, аж ахуйн хэлтэст-2, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэст-3, Бүртгэл, техник технологийн хэлтэст-1, Захиргаа удирдлагын хэлтэст-1 тус тус санал ирсэн байна.

Шийдвэрлэсэн байдал: Гомдлын дагуу боломжгүй тухай хариу өгсөн 52, гомдол гаргагчид мэдээлэл өгч иргэний талд шийдвэрлэсэн 52, шийдвэрлэх шатандаа байгаа 4 санал байна.

Иргэдээс ирүүлсэн саналын дагуу шинээр өөрчлөлт оруулсан чиглэлүүд:

1.Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу холбогдох судалгааг хийж М:1 чиглэлийн богино эргэлтийг М:1а "5 шар- Мөнгөн Завьяа", М:1б "Сүхбаатарын талбай- Офицеруудын ордон" гэсэн 2 хувилбараар боловсруулсан. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/27 тушаалаар тус чиглэлийн замналыг баталж, үйлчилгээг 2025 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлүүлэхээр нэгдсэн даалгаварт тусгаад байна.

2. Ч:71 “120 мянгат-Хүннү 2222-Баянмонгол хороолол-МУБИС-Сүхбаатарын талбай” чиглэлийн зорчигч урсгал болон эрэлтийн судалгааг хийж, тухайн чиглэлд өөрчлөлт оруулах төлөвлөлтийг боловсруулсан. Төлөвлөлтөөр Ч:71 “120 мянгат-Хүннү 2222-Баянмонгол хороолол-МУБИС-Сүхбаатарын талбай” чиглэлийн

гаралтын тоог нэмэгдүүлж хүлээлгийн хугацааг багасгах, мөн чиглэлийн замналд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн.

3.Тус газраас иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн. Үүнд: Энхтайваны өргөн чөлөө дагуу М:1а "5 шар- Мөнгөн завъяа", М:1б "Офицеруудын ордон- Сүхбаатарын талбай" чиглэлийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр нээсэн. Үндсэн М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн энэ оны 01 дүгээр сарын зорчилт 1,357,280 байсан нь 04 дүгээр сард зорчилт нэмэгдсэн чиглэлүүдийн нийлбэрийн хамт 1,485,809 болж 128,529 зорчилтоор буюу 9.4 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

4.Мөн Хан-Уул дүүрэгт зорчдог иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор богино эргэлтийн Ч:7А "Нисэх-5 Богд компани", М:3А "Архивын ерөнхий газар-Таван богд компани" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс шинээр нээсэн.

5.Нийслэл Улаанбаатар хотод шинээр баригдсан Сонгинохайрхан дүүргийн 14, 21, 31, 43-р хороо, Баянгол дүүргийн 10, 22-р хороо, Баянзүрх дүүргийн 17,18,19, 27-р хороодын гэр хорооллын дундах 14 байршлын авто замын нөхцөл байдлыг 2025 оны 05 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд газар дээр нь судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Судалгаанд хамрагдсан гэр хорооллын 14 байршлын дундах авто замын 12 байршилд хороолол дундах замын нөхцөл байдал болон дэд бүтцээс үүдэлтэй нийтийн тээврийн дунд оврын автобус үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна. Авто замын хэвтээ, босоо тэмдэглэлийн сайжруулалт хийж, дундын болон эцсийн зогсоол хийсний дараа 2 байршилд нийтийн тээврийн дунд оврын автобус үйлчлэх боломжтой нь тодорхойлогдсон.

Одоогоор гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын цэгүүдэд 8 чиглэлд дунд багтаамжийн 17 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна.

Нийтийн тээврийн чиглэлүүд нэршлээр:

- Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ төлөвлөлтөөр Нийслэл Улаанбаатар хотын хойноос урагш, баруун зүүн цэгүүдийг холбосон төвийн "М:..." буюу магистрал-9,
- Төвийн гол чиглэлүүдийг холбосон үндсэн "Ч:..." чиглэлийн 77, "Ү:..." чиглэлийн 11,
- Хот орчмын "Х:..." чиглэлийн 20, дунд багтаамжийн тээврийн хэрэгслийн "Д:..." чиглэлийн 8,
- Шөнийн үйлчилгээний "ШҮ:..." чиглэлийн 3,
- Ажилчдын "АТ:..." чиглэлийн 2 буюу нийт 133 чиглэлээр иргэдэд зорчигч тээврийн үйлчилгээг хүргэж байна.


Улаанбаатар хотын гол гудамж замууд болох Энхтайваны өргөн чөлөөгөөр 7 чиглэлийн 150 автобус, Чингисийн өргөн чөлөөгөөр 11 чиглэлийн 157 автобус, Их тойруугаар 13 чиглэлийн 161 автобус, Нарны замаар 5 чиглэлийн 53 автобус үйлчилж байна.




4. Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо-Улиастайн шинэ эцэс",
5. Д:13 "Улиастайн шинэ эцэс-Шархадны эцэс" чиглэлүүдийг тус газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталж, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.



Зураг 12. Гэр хороололд шинээр хүрсэн чиглэлүүдийн хамрах хүрээний зураглал




### Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны талаар:



- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 7 хоног 21 цаг 9 минут байгаа нь нийслэлийн дундаж хоногт багтаан шийдвэрлэж байгаа үзүүлэлттэй байна.

### Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийн талаар



- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад гаргасан зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 98.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.
- 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 10 зөрчил тооцогдсон байгаагаас өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 5, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил 2, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 2 байна.

Албан хаагчдаар нь харуулбал:

Д/д	Хэлтэс	Албан тушаал	Албан хаагч	Өргөдлийн дугаар	Зөрчлийн дэлгэрэнгүй	Зөрчил бүртгэсэн	Зөрчлийн огноо	Тоо
1	НТБГ: Удирдлага	Дарга	Д.ОТГОНЖАРГАЛ	O250319001	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил fp1	Систем	2025-03-20	1
2	НТБГ: Удирдлага	Дарга	Д.ОТГОНЖАРГАЛ	G250319014	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил fp1	Систем	2025-03-20	1
3	НТБГ: Удирдлага	Дарга	Д.ОТГОНЖАРГАЛ	O250618001	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил fp2	Систем	2025-06-19	1
4	НТБГ: Тээврийн бодлого, судалгааны хэлтэс	Хэлтсийн дарга	Д.БАЯСГАЛАН	O250122054	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил fp2	Систем	2025-01-24	1
5	НТБГ: Санхүү, аж ахуйн хэлтэс	Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Бадамдорж	W250123001	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил fp1	Систем	2025-01-24	1
6	НТБГ: Санхүү, аж ахуйн хэлтэс	Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Бадамдорж	G250820041	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил fp2	Систем	2025-08-27	1
7	НТБГ: Тээврийн бодлого, судалгааны хэлтэс	График, мэдээллийн сан, сүлжээний инженер	Э.ЛХАГВАДОРЖ	G250120084	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо fp4	Систем	2025-02-04	1
8	НТБГ: Зорчигч тээврийн хэлтэс	Хэлтсийн дарга	Б.Дөлгөөн	C250206012	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил fp1	Систем	2025-02-07	1
9	НТБГ: Бүртгэл, техник технологийн хэлтэс	Хэлтсийн дарга	М.Мөнхбаяр	O250123022	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил fp1	Систем	2025-01-24	1
10	НТБГ: Хуулийн хэлтэс	Хуулийн ахлах зөвлөх	Б.ЭРДЭНЭБИЛЭГ	O250115019	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо fp4	Систем	2025-02-06	1
Нийт								10

- Мөн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр ирсэн 328 өргөдөл, гомдлыг цаг тухай бүр шийдвэрлэн ажилд авах, чөлөөлөх, чөлөө олгох, тусламж дэмжлэг

үзүүлэх чиглэлээр Газрын даргын тушаал гарч өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллалаа.

- Тухайн 7 хоногт шийдвэрлэгдсэн, зөрчил тооцогдсон албан хаагч тус бүрээр дүн мэдээг гарган 4 дэхь өдөр болгон Нийслэлийн Засаг даргын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв-рүү албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд тулган шийдвэрлэсэн, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил гаргасан 7 албан хаагчид анхааруулан ажиллалаа.

- Тус газрын хуулийн хэлтэс нь өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн UB ERP нэгдсэн системд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд дүгнэлт, танилцуулга хийж газрын даргад танилцуулан ажилласан.

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, ERP нэгдсэн системд бүртгэн ажиллаж байгаа хэдий ч иргэний төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж, түүнийгээ хуулийн дагуу шийдвэрлүүлэх, үндэслэл бүхий хариу авах эрх зарим байдлаар зөрчигдөж байгаа талаар тус газрын дарга нийт албан хаагчдад ERP нэгдсэн систем-ээр дамжуулан үүрэг даалгавар өгсөн.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МЯГМАР

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ГОМДОЛ ХАРИУЦСАН АХЛАХ АЖИЛТАН

С.БИЛГҮҮН